# ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

2024 оны 07-р сарын 09-ний байдлаар

Тус хэлтэс нь иргэдээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж журмыг байгууллагын хэмжээнд боловсруулан мөрдөн ажиллаж, ажилтнууд оны эхнээс ажлаа төлөвлөн ажлын төлөвлөгөө графикийг 7 хоногоор батлуулж, өрөөнийхөө үүдэнд хадаж, иргэдэд ажлаа ил тод нээлттэй, түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж байна.. Эрхэлсэн ажлын чиглэлээр ажилтан тус бүр иргэдэд зориулсан зөвлөмж гарын авлагаар тогтмол хангадаг бөгөөд үйлчлүүлэхээр ирсэн иргэдэд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, сонирхсон асуудлаар чиг баримжаа олгох, гарын авлагаар хангах зэрэг үйлчилгээг үзүүлж хэвшээд байна. Үүний зэрэгцээ иргэдийн өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэх, иргэдийг мэдээ мэдээллээр хангах талаар хэлтсийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажиллалаа.

Иргэдийн хамгийн их бухимдал төрүүлдэг гол сэдвүүд болох жин хэмжүүр, даралтын аппарат, цахилгаан тоолуурын баталгаажуулалт болон шатахуун түгээгүүрүүд бензин түлшээ дутуу шахдаг гэсэн гомдол, бухимдал их гардаг. Энэ эргэлзээг арилгахын тулд иргэд, хэрэглэгчдэд зориулсан мэдээ мэдээллийг ил тод байдлаар тогтмол хүргэж, иргэдийн эргэлзээг арилгаж ажилласнаар тайлант хугацаанд иргэд, хэрэглэгчдээс ямар нэг өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирээгүй байна.




ТАЙЛАН ГАРГАСАН Б.ГЭРЭЛ